



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 03 сарын 18 өдөр

Дугаар А/Н

Улаанбаатар хот

“Нарны баяр-2025” арга хэмжээг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/332 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/155 дугаар захирамжаар батлагдсан “Нийслэлийн аялал жуулчлалын газрын дүрэм”-ийн 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалт, 7 дугаар зүйлийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.Тусгай сонирхлын аялал жуулчлалыг хөгжүүлэх, жуулчны улирлын хугацааг уртасгах, иргэдийн амралт, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх Улаанбаатар хотыг зорин ирэх жуулчдын тоог нэмэгдүүлэх зорилгоор “Нарны баяр- 2025” арга хэмжээг 2025 оны 03 дугаар сарын 22-ны өдөр зохион байгуулсугай.

2.“Нарны баяр-2025” арга хэмжээг зохион байгуулах төсвийг хавсралтаар баталж шаардагдах 197,396,800 (нэг зуун ерэн долоон сая гурван зуун ерэн зургаан мянга найман зуун) төгрөгийг холбогдох зардлаас гаргахыг Ахлах нягтлан бодогч (Д.Мөнхгэрэл)-д зөвшөөрсүгэй.

3.Арга хэмжээг зохион байгуулах ажлын төлөвлөгөөг батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж, ажлын үр дүнг танилцуулж ажиллахыг Бодлогын хэрэгжилтийн хэлтэс (С.Туул)-т даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

۵۵/۲

۲۵۰ ۴۵ ۶۶

پھر و ہنس لہر پھل

9 • D. Baby

مستحقين D Baby . وبقدره

Нийслэлийн Аялал жуулчлалын газрын
даргын 2025 оны 03 дугаар сарын 18-ны
өдрийн А/11 дугаар тушаалын хавсралт

“НАУРЫЗЫН БАЯР” АРГА ХЭМЖЭЭГ
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

2025 оны 03 дугаар сарын 18

Улаанбаатар хот

№	Төрөл нэрс	Хэмж их нэгж	Тоо	Нэгж үнэ	Нийт үнэ
БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН НУТГИЙН ЗӨВЛӨЛ					
1	Казах бүрэн тоноглол дастархантай ГЭР	ш	6	3,000,000	18,000,000
2	Масс номерын бүжгийн хувцас	ш	50	300,000	15,000,000
3	Бүжгийн парлогийн 36 хувцас	ш	36	250,000	9,000,000
4	Дүрс бичлэг, зураг авах баг студи	багц	-	-	5,000,000
5	СТУДИ парлог найруулга		-	-	8,000,000
6	Тойрон бүжиг казах үндэсний, Бүжгийн хамтлаг, Домборын 50 хүүхдийн бичлэг дууны дэвсгэр найруулга	ш	50	100,000	5,000,000
7	Үндэсний тоглоом, дэвжээ засах талбай тохижуулалт	ш	1	8,000,000	8,000,000
8	Найруулагч	хүн	1	5,000,000	5,000,000
9	Хөдөлгөөний найруулагч	хүн	2	1,500,000	3,000,000
10	Хөтлөх, туслах найруулагч, менежерүүд	хүн	6	500,000	3,000,000
11	Масс номерын оролцогчид	хүн	100	30,000	3,000,000
12	ЭТНО хамтлаг хувцас, хөгжим, үндэсний үзүүлбэрүүд 20 хүн	багц			10,000,000
13	Уран бүтээлчдийн хөлс	хүн	28	500,000	14,000,000
14	Домборын уран бүтээлч	хүүхэд	50	100,000	5,000,000
15	Хөтлөгчид		5	800,000	4,000,000
16	Үндэсний тоглоом, дэвжээ оролцогч нарын хөлс 18 хүн	хүн	18	300,000	5,400,000
17	Нэмэлт дастархан зардал, Үндэсний хоолны амталгаа	ш	Багц	1,000,000	1,000,000
Нийт					121,400,000
НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР					
1	Монгол банхрын үзүүлбэр, зураг авхуулах орчин	ш	5	1,500,000	1,500,000
2	Шувуулахуйн биет бус уламжлалт өв соёл болон махчин шувуудын танин мэдэхүйн хөтөлбөр	ш	Багц	2,250,000	2,250,000
3	Цагдаагийн албан хаагчдын үүрэг гүйцэтгэх үеийн зардал	-	38хүн 7 авто машин	1,046,800	1,046,800

4	Цахилгаан холболт, ажиллах хүчний зардал	-	Багц	4,400,000	4,400,000
5	Мэргэжилийн уран бүтээлчид /Морин хуурын чуулга, бүжигчид, бусад/	Хүн	-	15,000,000	15,000,000
6	Шторк, geel, постер бэлтгэх, бүүст хийх, дүрс зураг авах, контент хийх	ш	Багц	4,500,000	4,500,000
7	Асар түрээс	ш	20	165,000	3,300,000
8	Хэвлэл	ш	Багц	100,000	5,000,000
9	Хөгжим лед дэлгэц түрээс	багц	400ш лед 40ш гэрэл Хөгжим	30,000,000	30,000,000
10	Тайзны хэвлэл	ш	28м*5,5 8м*2,4м- 2ш	9,000,000	9,000,000
Нийт					75,996,800
Баян-Өлгий аймгийн нутгийн зөвлөл					121,400,000
Аялал жуулчлалын газар					75,996,800
Нийт					197,396,800